

2020 он 5 сар 1 өдөр

Дугаар 20/01

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдөр live.ard.mn цахим хуудсаар дамжуулан 14:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга П.Батбаяр хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, Тооллогын комиссын даргыг хурлын ирцийг танилцуулахаар урив.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх танилцуулснаар: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 28,614,263 ширхэг хувьцаанаас саналын эрхгүй 8,727,176 ширхэг байна, нийт саналын эрхтэй 19,887,087 хувьцаанаас саналын эрх бүхий энгийн хувьцааны 12,878,762 ширхэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа нь нийт хувьцаа эзэмшигчдийн 64.76% болж байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээллэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.13-ыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаярт мэдэгдэж, хурлыг нээв.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр хурлын дэгийг танилцуулан 2019 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж эхлэв.

Хурлын дэг:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хэлэлцсэн нь №1: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг:

Нэгтгэсэн үзүүлэлтийн хувьд өнөөдөр Ард Санхүүгийн Нэгдэл 386,749 харилцагч, 7,183 хувьцаа эзэмшигч, 68,078 даатгуулагч, 25,580 зээлдэгч, 69,550 брокерийн данс эзэмшигчидтэй болсон байна. Ганц ч салбаргүй үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьд маш сайн үзүүлэлт гэж бодож байна. 2019 онд нийт 19 компанид хөрөнгө оруулалт хийгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Манай нийт хөрөнгө 2018 оны сүүлээр 67.2 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 76.8 тэрбум төгрөг болсон байна. Нийт цэвэр орлого 17.6 тэрбум төгрөгт хүрсэн бол нэгтгэсэн цэвэр ашиг 6.6 тэрбум төгрөгтэй гарсан байна. 2017 онд бид улсад 1 тэрбум төгрөгийн татвар төлдөг байсан бол 2019 онд 2 тэрбум төгрөгийн татварыг төлдөг компани болсон байна. 2019 он бидний хувьд олон үйл явдалтай жил болсон. 2019 оны 1 сард Ард Аппликейшн нэвтрүүлсэн, анх удаа

АрдКойн хэтэвчийг танилцуулж байсан. Бид анх удаа хувьцаа эзэмшигчиддээ АрдКойноор хувь тэнцүүлсэн урамшуулал өгсөн. Мөн манай Төлөөлөн Удирдах Зөвлөл 2019 оны гүйцэтгэл дээр үндэслэн 1 тэрбум төгрөгтэй тэнцэх ногдол ашиг нийт хувьцаа эзэмшигчдэд хуваарилж байгааг та бүгдэд дуулгасан байгаа. Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2019 чуулган болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн-2020 чуулган “Ирээдүйдээ эзэн байя” уриан дор 2019 ондоо хоёр удаа зохион байгуулагдсан байна. Ард Санхүүгийн Нэгдэл Жинс Увстай нэгдсэнээр 8 сарын 8-ны өдрөөс эхлэн Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй арилжаалагдаж эхэлсэн. Мөн Ард Даатгал, Ард Кредит, Монгол Шуудан, Ард Санхүүгийн Нэгдэл өнөөдөр Монголын Хөрөнгийн Биржийн нийт арилжааны ихэнх хувийг эзэлдэг болсон байгаа. 2020 оны 1 дүгээр сард Монголын Хөрөнгийн Бирж манай дөрвөн компанийн хувьцааг ТОП20 гэдэг индексдээ оруулсан. АрдШоп компани маань үйл ажиллагаагаа эхлүүлж БНХАУ-ын SFXpress компанитай холболт хийж гадаад захиалга хийх боломжтой болсон. Ард Лайф компанийн гүйцэтгэх захирлаар Б.Гантулга, Ард Кредитын гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэн томилогдов. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар Э.Амарбаясгалан, Хууль эрх зүй, хянан нийцүүлэлт эрхэлсэн захирлаар С.Анар-Эрдэнэ, Эрсдэлийн менежерээр Б.Оюутцэцэн нар томилогдов. Ард Лайфыг дахин хөрөнгөжүүлэх, үйл ажиллагааг нь тэлэх зорилгоор 14 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ, Монгол Шуудангийн 3.6 хувийг нэмж авлаа. Ард Секюритиз компани маань хууль ёсны дагуу гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

Манай хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувь 2018 онд бид 2,898 хувьцаа эзэмшигчидтэй байсан бол 2019 онд 4,063 хувьцаа эзэмшигчидтэй болсон байна. 2018 онд 17,194,364 ширхэг хувьцаа эргэлтэнд байсан бол 2019 онд 28,614,263 ширхэг болсон байна. Үүнд топ хувьцаа эзэмшигчид 68.5 хувь буюу 19,613,979 ширхэг хувьцаа эзэмшиж байна, бусад хувьцаа эзэмшигчид 26.5 хувь буюу 7,561,650 ширхэг хувьцаа эзэмшиж байна, халаасны хувьцаа 5.0 хувь буюу 1,438,634 ширхэг хувьцаа болсон байна. Хөрөнгө оруулалтын бүтцийн хувь Ард Лайф, Ард Секюритиз, Ард Менежмент, Ард Лизингийг 100 хувь эзэмшиж байна. Ард Даатгал дээр 66.8 хувь, Ард Кредит 60.8 хувь, Ард Актив 10 хувь эзэмшиж байна. Бусад хөрөнгө оруулалтын хувьд Тэнгэр Системс, Монгол Шуудан, АрдШоп, Номын Хишиг, Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоо гэсэн байгууллагуудад мөн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Танилцуулсан нь: Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо:

2019 онд манай нийт үнэлгээ 59.6 тэрбум төгрөгт хүрч 13 хувиар өссөн байна, цэвэр ашиг 3.4 тэрбум төгрөгт хүрсэн байна, нийт ашгийн хувьд 5.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын багцын хувьд 2019 онд манай стратегийн хөрөнгө оруулалтын багц 44 тэрбумаас 67.3 тэрбум төгрөг болсноор энэ нь 67 хувийн өсөлтийг 1 жилийн хугацаанд үзүүлсэн байна. 2019 онд нийт хөрөнгөө 19 хувиар нэмэгдүүлж 78.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Эздийн өмч буюу манай хувьцаа эзэмшигчдийн цэвэр хөрөнгө 2019 онд 12 хувиар өсөж 56.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Санхүүгийн байдлын тайлангийн хувьд манай нийт хөрөнгө 78 тэрбум төгрөгт хүрч 1 жилийн хугацаанд 29 хувиар өссөн байна, нийт өр төлбөр 9.9 тэрбумаас 21.5 тэрбум төгрөгт хүрсэн байна, нийт эздийн өмчийн дүн 50.5 тэрбумаас 56.6 тэрбум төгрөг болж 12 хувиар өссөн байна. Орлого, үр дүнгийн тайлангийн хувьд нийт орлого 5.3 тэрбумаас 124 хувиар

өссөнөөр 11.8 тэрбум төгрөгт хүрснээр байна, нийт зардал 4.5 тэрбумаас 62 хувь өсөж 7.3 тэрбум төгрөгт хүрснээр манай татварын өмнөх ашиг маань 4.4 тэрбум төгрөг болсон байна. Ингэснээр манай цэвэр ашиг 3.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь 2018 оны үзүүлэлтээс 410 хувиар их үзүүлэлт болсон байна. Дахин үнэлгээний олз буюу манай хөрөнгө оруулалтуудын үнэлгээний олзууд энэ дансанд бүртгэгддэг бөгөөд 2019 онд 2 тэрбум төгрөгийн олз бүртгэгдсэнээр нийт дэлгэрэнгүй орлого 5.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Танилцуулсан нь: Дотоод аудитор М.Мөнх-Эрдэнэ:

Далайван аудит 2017 оноос 2019 онуудын хараат бус аудитаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон ажилласан байна. 2019 оны Далайван аудитын хураангуй аудитын тайлангийн дүгнэлтийг танилцуулж байна. 2019 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт нь материаллаг зүйлсийн хувьд олон улсын стандартад нийцэж байна гэсэн санал дүгнэлтийг өгсөн байна. Энэ нь стандарт буюу ямар нэгэн өөрчлөлтгүй, хязгаарлалтгүй гэсэн хамгийн сайн дүгнэлтийг авсан байна. Мөн Далайван аудитаас дагаж мөрдөх 12 зөвлөмжийг өгсөн байгаа.

Хэлэлцсэн нь №2: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дарга П.Батбаяр:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь тайлант онд тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр зөвлөмж төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

ТУЗ-ийн баталсан 2019 оны Бизнес төлөвлөгөөний гол зорилго нь эхний хагас жилдээ багтан Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Жинст Увс ХК-тай нэгдэж Монголын Хөрөнгийн Бирж дээр чөлөөтэй арилжаалагддаг компани болох ба Монгол Улсад анхны блокчэйн дээр суурилсан АрдКойн (ARDX) нэвтрүүлэх байлаа. Мөн Ард Аппликейшн ашиглан Монголын Хөрөнгийн Бирж болон trade.mn дээр арилжаа хийх боломжийг олгох нэмэлт функцуудтэй Ард Аппликейшны 2-р хувилбарыг гаргах төлөвлөгөөтэй байсан.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК 2019 оны 8-р сард Жинст Увс ХК-тай нэгдэж хувьцаа нь Монголын Хөрөнгийн Бирж дээр AARD тикер дор арилжаалагдаж эхэлсэн байна. 2019 оны 4-р сард АрдКойн анхлан гаргаж хувьцаа эзэмшигчдэдээ 1 тэрбум төгрөг тэнцэхүйц АрдКойнийг хувь

тэнцүүлсэн урамшуулал болгон олгосон бөгөөд АрдКойн нь CoinMarketCap, Blockfolio, LiveCoinWatch зэрэг тэргүүлэх платформууд дээр орж чадсан байна. Мөн 2019 оны 12-р сард “Хөрөнгө Оруулагч” Форумын үеэр Ард Аппликейшны 2-р хувилбарыг олон түмэндээ танилцуулжээ.

2019 оны 12-р сарын ТУЗ-ийн ээлжит хурлаар компанийн 2020-2022 оны шинэчилсэн зорилт, зорилгуудыг хэлэлцэн баталсан. Үүнд, эрхэм зорилгоо “Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно”, алсын хараа “Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох” хэмээн тодорхойлсон. Үүний дагуу дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

2019 онд нийт үйл ажиллагааны хувьд 3.4 тэрбум төгрөг буюу нийт 5.4 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашигтай ажилласан бөгөөд энэхүү ашгаасаа 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчиддээ тараах шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл 2020 оны 2 сард гаргалаа.

Иймд 2019 он Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьд асар том амжилттай жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан төлөвлөсөн зорилтоо биелүүлэн ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

Асуулт, хариулт

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Ганбаатар, Ган-Эрдэнэ.

Энэ жил ногдол ашиг хэрхэн өгч байгаа вэ? Цаашид ногдол ашиг яаж өгөх вэ?

Хариулт. Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг: Ногдол ашгийн хувьд бол бид нар түрүү жил 1 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хувь тэнцүүлсэн урамшууллыг АрдКойноор өгсөн. АрдКойн Бирж дээр бүртгэгдээд 2019 оны дундуур 7-8 төгрөг хүрсэн. Компанийн хувьд 1 тэрбум төгрөгийн зардал гаргаж АрдКойн хуваарилсан байгаа. Энэ жил манай Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн үр дүнг харж байгаад мөн 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчиддээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Дүгэрхүү, Мөнхбаяр, Бямбасүрэн, Эрдэнэ-Баатар, Батжаргал, Батнасан.

Хувьцааны үнэлгээ бодит үнэлгээндээ хэзээ очих вэ? Хувьцааны үнэ одоо ямар байгаа вэ? Компанийн зүгээс ямар арга хэмжээ авч байгаа вэ? Цаашдын хувьцааны төлөв ямар байгаа вэ?

Хариулт. Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг: Ард Санхүүгийн Нэгдлийн дөрвөн компани өнөөдөр арилжаалагдаж байна. Монголын Хөрөнгийн Бирж дээр манайх хамгийн их дүнгээр арилжаалагдаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Бирж дээр авах болон зарах захиалгыг хамгийн ихээр авч байна. Гэсэн хэдий ч манай хувьцаа эзэмшигчид буюу зарим хамтрагчид маань хувьцаагаа зарж байгаа явдал нь манай хувьцааны үнийг дарж байдаг. Гэхдээ манай компанийн хувьцааг бусад компаниудтай харьцуулбал өнөөдөр Монгол Улсын эдийн засаг тогтворгүй байгаа үед манай компанийн хувьцаанууд үнэ цэнээ хадгалж чадаж байна. Зах зээлийн бодит үнэд яаж хүрэх вэ гэвэл бид илүү сайн ажиллаж олон хүмүүсийн итгэлийг татах явдал юм. Энэ дээр хувьцаа эзэмшигчид та ямар хувь нэмэр оруулах вэ гэвэл компанийн хувьцааг худалдан авч

байгаагаа бусад хүмүүст уриалан манай компаниудын хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх юм. Ингэснээр компанийн хувьцаа эзэмшигчид маань нэмэгдэж хувьцааны үнэ зах зээл дээр өсөх болно.

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Тэрбиш Баасанбат, Намхайдагва Баттулга.

Тэтгэврийн шинэчлэлтэй холбоотой Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс хэрхэн оролцож байгаа вэ?

Хариулт. Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг: Тэтгэврийн тогтолцоо Монгол Улсад сайн биш байгааг хүн бүр мэдэрч байна. Бид насаараа ажиллаад, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал төлж явчхаад сайн үйлчилгээ авч чаддаггүй. ХасБанк дээр 2007 оноос эхлэн ажилчиддаа тэтгэврийн хувийн санг байгуулж байсан. Энэ ажил өнөөдөр Ард Лайф дээр явагдаж байна. Энэ асуудал олон хүмүүсийн анхаарлын төвд ороод тэтгэврийн шинэчлэл хийх шаардлагын талаар өнөөдөр маш хүчтэй ярих болсноор залуу УИХ гишүүн Н.Учрал энэ ажлыг удирдан хуулийг эцсийн байдлаар боловсруулж, УИХ хуралд барихаар бэлэн болоод байна. Үүний дагуу Ард Лайф зөвшөөрлөө авах болно.

Асуулт, хариулт дуусав.

Санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /19,887,087 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,878,762 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /19,887,087 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,878,762 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /19,887,087 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,878,762 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
19,887,087	100%	12,450,617	96.68%	19,887,087	100%	0	0%	19,887,087	100%	0	0%

Хурлын шийдвэр:

Хурлын дарга П.Батбаяр: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.

Хурал 17 цаг 00 минутанд дуусав.

ХЯНАСАН:
Хурлын дарга

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга



П.Батбаяр

Х.Хулан